

түвшинд гэж үзнэ.

3. Хүн бүр өөрөө бэрхшээл хүндрэлийг давж гарах хариуцлага хүлээнэ. Үйлчилгээнд үйлчлүүлэгч нь туслах үйл явцыг удирдаж болно. Эдгээр үйл явц олон түвшинд явагдана.

4. Бүх хүмүүс угаасаа сурах, өсч хөгжих, өөрчлөгдөх чадвартай.

5. Хувь хүнд олон нийт дунд нь, орон нутагт нь үйлчилгээ үзүүлэх туслах үйл явц нь давуу талд тулгуурласан, хүн төвтэй байхыг дэмжинэ.

6. Үйлчлүүлэгчид олон нийт, орон нутаг нь нөөц болно. Сэтгэцийн эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ гэх мэт албан, гэхдээ саланги тархай нөөцүүдийг бодвол албан бус буюу амьдралд өөрөө бүрэлдэж буй болдог нөөцүүдийг эн тэргүүний боломж гэж үзнэ.

Орчин үеийн дэлхийн нийтийн хандлагын хувьд эдгээр онолуудыг нэгийг нь хэтэрхий дөвийлгөх бус хослуулан аль аль талынх нь сайшаалтай болон саар талыг нь харгалзан авч үздэг болжээ. Уг чанартаа ял нь хүмүүжүүлэх, урьдчилан сэргийлэх гэсэн үндсэн зорилготой байдаг бөгөөд харин цээрлүүлэх нь ялын тусгай зорилгод орох учиртай.

Суллагдах ялтанд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээнд чадваржуулах болон давуу талд тулгуурлах онолын үзэл баримтлалыг ашиглах нь илүү өгөөжтэй гэж үзэж байна.

* * *

У.ХИШИГБААТАР



ХСИС-ийн Удирдлагын
сургуулийн 821 дүгээр
дамжааны сонсогч, ахмад

ЯЛТНЫ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ЭРХИЙГ ХАНГАЖ ИРСЭН УЛАМЖЛАЛ

Монгол улсад шинжлэх ухааны эмнэлэгт тулгуурласан эрүүл мэндийн албаны үүсэл, хөгжил, түүхэн замналыг:

-1921-1940 оны үе буюу БНМАУ-д орчин цагийн анагаах ухаанд суурилсан эрүүл мэндийн албыг бүрдүүлж эхэлсэн үе,

-1941-1990 оны үе буюу Социалист эрүүлийг хамгаалах номлолоор замнасан үе,

-1991 оноос одоог хүртэлх үе буюу Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үеийн эрүүл мэндийн албаны хөгжил гэсэн гурван томхон үе болгон авч үзэж болох юм.

1924 онд батлагдсан БНМАУ-ын анхдугаар үндсэн хуульд хүн амаа эрүүл мэндийн үнэ төлбөргүй тусламжид бүрэн хамруулахаар шийдвэрлэсэн нь нэн зоримог, алсын хараатай, зөв шийдэл байжээ. Үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх үүднээс эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагыг 1925 онд анх Дотоод яамны бүрэлдэхүүнд Ардын эрүүлийг хамгаалах газар нэртэйгээр байгуулж, 1930 онд бие даасан яам болгон өргөтгөсөн байна.¹⁷⁵

Эрүүл мэндийн яам, Чөлөөт нэвтэрхий толь

1941-1990 оны хоорондох 50 жил бол БНМАУ-д социалист эрүүлийг хамгаалахын зарчмуудыг тууштай хэрэгжүүлсэн он жилүүд бөгөөд төрийн бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн дэс дараатай арга хэмжээнүүдийн үр дүнд тус улсын хот, аймаг, сум, сангийн аж ахуйн төв зэрэг төвлөрсөн суурин газрын хүн амыг их эмчийн ерөнхий мэргэжлийн тусламжаар үндсэнд нь бүрэн хамарч, анагаах ухааны гол салбаруудаар эмнэлгийн төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламжийг хөгжүүлж, үндэстний мэргэжилтнүүд цээжний хөндийн болон тархины мэс засал, сэхээн амьдруулахын тусламжийг үзүүлэх арга барил, ур чадварыг эзэмшиж, дотуур дурандалт, дүрс оношлогоо, хүний генетик, вирус болон дархлал судлалын аргуудыг эмнэлгийн практикт нэвтрүүлж эхэлсэн байлаа.

1989 оны төгсгөлд 10000 хүн амд 27.4 их эмч, тусгай дунд боловсролтой 87.3 мэргэжилтэн, 117.9 эмнэлгийн ор ногдох болсон нь 1940 оныхтой харьцуулахад 10000 хүн амд ногдох их эмч 18 дахин, дунд шатны мэргэжилтэн 2 дахин, эмнэлгийн орны тоо 5 дахин өссөн гэсэн хэрэг бөгөөд дэлхийн хөгжингүй орнуудын жишигт хүрсэн үзүүлэлтүүд байв.

Энэ чиглэл нь 1992 онд батлагдсан "Монгол улсын үндсэн хууль"-д "Монгол улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно", "эрүүл мэндээ хамгаалах нь иргэн

бүрийн журамт үүрэг мөн" хэмээн тусчээ.

Ялтны ахуй хангамжинд эмнэлгийн үйлчилгээ хамгийн шийдвэрлэх үүрэгтэй билээ. Ялтанд хуулийн дагуу төрийн зохих албадлага шаардлага хэрэглэхийн хамт, иргэн, хүний нь хувьд эрүүл мэндийн болон ахуй хангамж нөхцлийг адил анхаарах ёстой гэж төр үзэж иржээ. Ялтан хүнийг төр, улс мэдэлдээ авч тэднийг хүмүүжүүлж, аюулгүй бадлыг хангах үүрэг хүлээдэг тул тэдэнд хүний нь хувьд тавих халамж, ялангуяа эмнэлгийн үйлчилгээг огтхон ч сулруулахгүйгээр байлгаж, суллагдахад нь нийгэмдээ эрүүл саруул эргүүлж өгөх нь манай үндсэн үүрэг гэдэг шаардлагыг тавьж ирсэн байна.

Хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалт, уламжлал, шинэчлэл: Монгол оронд 1921 онд ялсан Ардын хувьсгалын дараах үед эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааг эрх зүйгээр зохицуулах асуудалд чиглэгдсэн бие даасан хуулиуд гарч, хэрэгжиж ирсний хамтаар ялтны эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон эрх зүйн зохицуулалт хийгдэж ирсэн түүхэн уламжлалтай.

1931 оны Монгол Ард Улсын дотор аливаа хэрэгтэн ялтныг засан сайжруулах ажлын тухай хууль:¹⁷⁶ Энэхүү хуулийн зорилго нь "Тус улсын дотор аливаа хэрэгтэн ялтныг хорих газруудыг байгуулах ба хорихгүйгээр албадан ажил хийлгэх явдлыг

¹⁷⁶ 1931' оны Монгол Ард Улсын дотор аливаа хэрэгтэн ялтныг засан сайжруулах ажлын тухай хууль:

гүйцэтгэж, уул хэрэгтэн ялтанг засан сайжруулах ажлыг хэрхэн гүйцэтгэх тухай дүрмийг баталсугай хэмээсэн бодлого болно”² гэж тодорхойлоод, аливаа тохионоогүй этгээдүүдээс гэмт явдал үйлдэхээс сэргийлэхэд засан сайжруулах ажлыг чиглүүлбэл зохихыг заажээ.

“Хоригдогсдын дотроос ажил үйлдвэрийг хийж чадахыг нь эрх биш бүгдийг нь ажилд хэрэглэх бөгөөд уул хоригдогсдоос хэн аль нь ямар ажилд авьяастай, мэдэх чадах нь юу болох, тэдгээрээс урьд хийж байсан ажил ба ¹⁷⁷биеийн эрүүл мэнд ямар болохыг хянан үзэж харгалзан гүйцэтгэвээс зохисмой³ хэмээн заасан нь эрүүл мэндийн байдлыг нь харгалзан ажилд гаргаж байжээ. Аливаа ялтан нас нөхцсөн тохиолдолд түний шалтгааныг эмчээр тодорхойлуулсны дараа шийдвэрлэдэг байжээ. **Ялтны хоолыг** өөрсдөөр нь хийлгэхдээ эмчийн зааврыг баримтлах, түр хоригдогсдод тусгай зөвшөөрлөөр 7 хоногт нэг удаа, бусад ялтанд хоёр удаа хоол оруулах, түүнчлэн ялтныг гаднаас авах, гадагш явуулах захидалд хяналт тавихад баримтлах журмуудыг заажээ.

БНМАУ-ын Дотоод явдлын яамны засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн лагерь, гянданд хоригдлыг байлгах тухай дүрэм: Ардын

СнЗ-ийн 1950 оны 126 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд энэ дүрмийн XIV бүлэгт Эмнэлэг, ариун цэврийн үйлчилгээний талаар бүрэн тусгаж байжээ.

1966 оны БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль: энэхүү хуулийн зорилт нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулсан ялыг хууль ёсоор эдлүүлж, тэднийг хууль ёсыг хүндэтгэн сахиж, социалист нийгмийн амьдрал, хөдөлмөрт хэвшүүлэн дахин хүмүүжүүлэх, тэднээс шинээр гэмт хэрэг үйлдэх буюу нийгэмд хортойгоор нолоолох явдлаас урьдчилан сэргийлэхэд орших бөгөөд ял шийтгэлийг эдлүүлэхдээ хүний бие махбодыг зовоох буюу хүн гэсэн нэрийг гутааж болохгүй гэж хуульчилсан нь Олон Улсын хүний эрхийг хамгаалах нийтлэг зарчимд нийцсэн зүйл болсон бөгөөд хуулийн 23 дугаар зүйлд: “гяндан, засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колани, хүмүүжил-хөдөлмөрийн колонид зайлшгүй шаардлагатай эмнэлгийн байгууллага үйлчилнэ. Ялтан нь эмнэлгийн үйлчилгээг үнэ төлбөргүй хэрэглэнэ. Хорих газрын эмнэлгийн байгууллага нь эмнэлэг, эмчлэн сэргийлэх ажлын талаар гарсан хууль тогтоомж, эрүүлийг хамгаалах байгууллагын тушаал заавар, аргачилсан зааврыг удирдлага болгоно” г эжээ. Мөн хуулийн 24-р зүйлд Хорих ял шийтгүүлсэн этгээдэд шүүхээс эрүүгийн хууль тогтоомжийн дагуу арьс өнгөний халдварт ба архины өвчнийг албадан эмчилгээ хийлгэхээр заасан бол түүнийг ял эдэлж байх хугацаанд нь албадан эмчилнэ.

Энэ хуулинд нилээд

¹⁷⁷ А Лхагваа, Х.Пүрэвсүрэн. Монгол Улсын эрүү иргэний хэрэгт холбогдох шүүхийн шийдвэрийг биелүүлэх хууль тогтоомжийн хөгжилт /1931-2005/. УБ., 2005. 45 дахь тал

БНМАУ-ын Дотоод явдлын яамны засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн лагерь, гянданд хоригдлыг байлгах тухай дүрэм

1966 оны БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль:

тодорхой хэлбэрээр заасан зүйл бол ялтны ахуй хангамж, эмнэлгийн үйлчилгээ, тэднийг албадан эмчлэх асуудал билээ. Ялтны сууцны дулаан хүйтний улиралд +16-аас +18 хэм байх, хүмүүжил хөдөлмөрийн клонид нэг хүүхдэд оногдох сууцны талбай 3 ам дөрвөлжин метр байх, түүнчлэн хоригдол бүрт ор буюу наар, орны цагаан хэрэглэл олгох, ял эдлэгчдэд улирлын байдалд тохируулан тогтоосон журмаар хувцас олгохыг хуульчлан баталжээ.

1981 оны БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль:¹⁷⁸ Хуулийн зорилт нь "ялсныг үйлдсэн гэмт хэрэгт нь цээрлүүлэх төдийгүй, хөдөлмөрт үнэнч шударга ханддаг, хуулийг нарийн чанд биелүүдэг, хамтын аж байдлын социалист хэв журмыг хүндэтгэдэг үзэлтэй болгон засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэх, ялсныг болон бусад хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхээс; урьдчилан сэргийлэх, эрүүгийн ял эдлэлтийн биелэлтийг хангах, түүнчлэн гэмт хэргийг арилгахад тус дөхөм үзүүлэх явдалд оршино." гэж тодорхойлоод, ял эддүүлэх нь хүний бие махбодийг зовоох, нэр алдрыг доромжлон гутаах зорилгогүйг заажээ.

Мөн хуульд ялтанд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээ, шаардлагатай тохиолдолд албадан эмчлэх талаар тодорхой заасан юм. Тухайлбал:

44-р зүйлд: Хорих газарт зайлшгүй шаардагдах эмнэлгийн байгууллага

ажиллана. Хорих газрын байранд эмчлэн сэргийлэх, халдварт өвчнийг эсэргүүцэх ажлыг БНМАУ-ын эрүүлийг хамгаалах яам хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна. Хорих ял эдэлж байгаа ялтанд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эмчлүүлэхэд эрүүлийг хамгаалах байгууллагын эмчилгээний газрын ашиглах болон энэ зорилгоор эмнэлгийн албаны хүмүүсийг ажиллуулах журмын БНМАУ-ын нийгмийн аюулаас хамгаалах яам, БНМАУ-ын Эрүүлийг хамгаалах яамтай хамтран тогтооно.

56-р зүйлд: Архаг архичин буюу мансууруулах зүйл хэрэглэгч ялсныг хорих ял шийтгэхдээ шүүхээс албадан эмчлүүлэх шийдвэр гарсан бол уг эмчилгээг засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын захиргаа энэ эмчилгээ хийлгэх нөхцлөөр хангана. Хэрэв ялтан архаг архичин буюу мансууруулах зүйл хэрэглэгч болох нь ял эдэлж байх үед илэрвэл засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллага уг ялтанд албадан эмчлүүлэх арга хэмжээ авахуулах хүсэлтээ шүүхэд гаргана. Ялтан хорих ял эдэлж дуусаад суллагдах үед эмчилгээ дуусаагүй бол засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын захиргаа эмнэлгийн дүгнэлт гаргуулж, уг этгээдийг хөдөлмөр эмчилгээний тусгай дэглэмтэй байгууллагад шилжүүлэх саналыг шүүхэд гаргана гэж заажээ. Хуулийн дээрх заалтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газар, холбогдох яамдаас хэд хэдэн тогтоол, тушаал гарган, хэрэгжилтийг зохион байгуулсан байна.

¹⁷⁸ 1981 оны БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль:

1993 онд “Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай хууль гаргаж, өмнөх хуулиндаа хоригдолд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээний талаарх заалтууд улам баталгаажсан бөгөөд хуулийн заалтыг хэрэгжүүлэхэд хорих байгууллагын нэгдсэн болон хорих ангиудын эмнэлэг ихээхэн үүрэгтэй байдаг. Холбогдох хууль тогтоомжийн заалтаас үндэслэн хорих байгууллагын эмнэлгийн албаны зорилтыг:

1. Ялтныг төрөл бүрийн өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн эмнэлэг гэгээрлийн ажил, сурталчилгаа зохиох

2. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх ажлыг шуурхай зохион байгуулах

3. Төрөл бүрийн өвчнөөр өвчлөгсдийг богино хугацаанд эрчимтэй эмчилж эдгэрүүлэх

4. Архаг архичид, мансууруулах бодис хэрэглэгчдийг илрүүлэн эмчлэх, шаардлагатай бол иргэний эмнэлгийн байгууллагад шилжүүлэх явдал гэж тодорхойлж болно.

1996 оны Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль:¹⁷⁹ Энэ хуулийн зорилт нь шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршиж байсан бөгөөд энэхүү хуульд хорих ангийн хүлээх үүрэг, зарим албан тушаалтны эрхийг тусгайлан зааж тодорхойлсон бөгөөд ялтныг ял эдлэх явцад хорих анги хүлээх

үүрэгт ялтны эрүүл мэндийг хамгаалах, хангах, нийгмийн аюултай халдварт өвчтэй болон согтуурах, мансуурах донтой хоригдлыг албадан эмчлэх, Хорих ангийн эрх бүхий албан тушаалтан хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхдээ дараах эрх эдлэхээр хуульчилж өгсөн. Үүнд:

-Хоригдлыг хорих ялаас хугацаанаас өмнө тэнсэн суллах буюу хорих ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих болон эмнэлгийн тодорхойлолтыг үндэслэн өвчний учир ялаас чөлөөлүүлэх тухай санал шүүхэд гаргах.

-Хуурамчаар болон санаатай өвчилсөн, эсхүл эрүүл мэнд, бие эрхтэндээ санаатайгаар гэмтэл учруулж эмчлүүлсэн, дур мэдэн ажилд гараагүй, чөлөөнөөс хоцорсон хугацааг тухайн ялтны ял эдэлсэн хугацаанаас хасч тооцох эрх эдлэхийг хуулиар зөвшөөрсөн байна.⁵

2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль:¹⁸⁰ Энэ хуулийн зорилтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, иргэний болон эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн үндэс, журмыг тогтооход оршино хэмээн хууль тогтоогчид тодорхойлж байсан. Хорих ял эдлүүлэх дэглэмийн болон бусад онцлогоос шалтгаалан эмнэлэгийн, үйлчилгээг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, бусад хууль тогтоомж, заавар

¹⁷⁹ 1996 оны Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль:

¹⁸⁰ 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль:

журмын хүрээнд явагддаг бөгөөд ялтны эмнэлгийн тусламж авах эрхийг **хуулийн 115** дугаар зүйлийн **115.1 дүгээр** зүйлд, үүргийг нь 115 дугаар зүйлийн **115.2.4** дэх зүйл, хэсэгт "эрүүл мэндээ хамгаалах, эмчийн зөвлөлгөө шаардлагыг биелүүлэх, хуурамчаар болон санаатайгаар өвчилсөн, эрүүл мэнд, бие эрхтэндээ гэмтэл учруулсан бол холбогдох зардлыг төлөх" гэж хуульчлан заасан байдаг.⁶

Хорих байгууллагын эмнэлэгт ялтныг хэвтүүлж эмчилсэн төлбөрийг Эрүүл мэндийн даатгалын журмаар шийдвэрлэж байна. Ялтныг хэвтэн эмчлүүлсэн хугацааг ял эдэлсэн хугацаанд тооцдог бөгөөд эрүүл мэнд, бие эрхтэндээ гэмтэл санаатайгаар учруулсан тохиодолд хасч тооцдог. Онц аюултай давтан гэмт хэрэгтнээр тооцогдсон, цаазаар авах ял нь уучлагдсан ялтныг бусад хоригдлоос тусад нь эмчлэх шаардлагаас тусгаарлан эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг. Мөн ил, далд хэлбэрийн сүрьеэ, ДОХ-оор халдварласан болон өвчилсөн ялтныг бусдаас тусгаарлан эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг. Хүнд өвчтэй ялтныг оношлох, эмчлэх явцад нарийн мэргэжлийн эмчийн тусламж авах шаардлагатай тохиолдолд Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2002 оны 313/2169 дугаар тушаалаар батлагдсан "Ялаас чөлөөлөх өвчний жагсаалт, хүнд өвчтэй ялтанд эмнэлгийн бусад байгууллагын туслалцаа үзүүлэх

журам"-д зааснаар шийдвэрлэдэг.¹⁸¹

Эмнэлгийн үйлчилгээний талаар: Дээрх гарсан хууль тогтоомж, заавар журмыг түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулж бүхий л ажил, арга хэмжээ авч ялтан эмнэлгийн үйлчилгээнд иргэний нэгэн адил хамрагдаж байсан боловч статистик тоо баримтаас үзэхэд ялтан хоригдогсдын дундах өвчлөлийн байдал буурахгүй эсрэгээрээ өсөх хандлагатай, өвчлөгсдийн нас залуужиж байгаад дүгнэлт хийж хорих ангид ял эдлэж байгаа ялтан болон цагдан хорих байранд хоригдож буй хоригдогч нарын дунд өвчлөлт болон нас баралт буурахгүй байсаар байна.

Ялангуяа сүрьеэ, зүрх судас, хавдар, бөөрний дутагдал, чихрийн шижин, цус харвалт зэрэг өвчлөлт хорих байгууллагад сүүлийн үед ихээр гарах болсон

* * *

¹⁸¹ "Төрийн мэдээлэл" сэтгүүл. 1997.№1.33-35 дахь тал

¹⁸¹ А.Лхагваа, Гяндан салаанаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болж өргөжсөн түүхэн замнал. УБ. 2001.170-175 дах тал
ШШГЕГ-ын ТГГ-ын Нэгдсэн эмнэлгийн тайлан